



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/299

Алтай хот

**Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын хугацааг сунгаж зохион
байгуулалтын арга хэмжээ авах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 188 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 03 дугаар албан даалгавар, Улсын Онцгой комиссын 2021 оны 21 дүгээр хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2021 оны 36 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн хугацааг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал орон нутгийн хэмжээнд буурахгүй байгаатай холбогдуулан 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл байгууллага, аж ахуйн нэгжийн нийт ажилчдын 30 хүртэлх хувийг ажиллуулж, бусад ажилчдыг цахимаар ажиллуулах нөхцөл боломжоор хангаж, дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Нэгдсэн эмнэлэг, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК, "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ, Алтай хотын Тохижилт үйлчилгээний газруудыг хэвийн горимоор ажиллуулж халдварын сэргийлэх хяналтын дэглэмийг чанд мөрдөж ажиллахыг тус тус үүрэг болгосугай.

4. "Алтайн хүдэр" ХХК-ийн хүдрийн уурхайд коронавирусын тохиолдол бүртгэгдэж "Улаан түвшин"-д шилжсэн, коронавирусын халдвар (Ковид-19)-ын цар тахлын тохиолдол нэмэгдэж байгаа тул 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийг дуустал ээлж солилцохыг хориглосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР